

**Төмрийн хүдрийн үйлдвэрлэлийн хөгжлийн хандлага,
дэлхийн зах зээлийн судалгаа дүгнэлт**

1. Дэлхийн төмрийн хүдрийн олборлолт, баяжуулалт, боловсруулалт хөгжлийн хандлага	2
1.1 Дэлхийн улс орны төмрийн хүдрийн олборлолт	2
1.2 Дэлхийн улс орны төмрийн хүдрийн баяжмалын экспорт, импорт	5
1.3 Дэлхийн төмрийн эрэлт нийлүүлэлт, үнийн хэтийн төлөв	6
2. Монгол орны төмрийн хэтийн төлөв байдал, хөгжлийн чиг хандлага	17
2.1 Монгол Улсын төмрийн хүдрийн нөөц, ашиглалт	17
2.2 Төмрийн хүдрийн хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаархи мэдээлэл	18
2.3 Монгол орны төмрийн хүдрийн ордуудыг ашиглах эдийн засгийн орчин	18
3. Судалгааны ажлын дүгнэлт	28

ӨМНӨХ ҮГ

Уул уурхайн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт, татвар, эрх зүйн орчин, түүхий эд бүтээгдэхүүний үнэ, ханш, эрэлт, хэрэгцээ дэлхий дахинд жил, сар, өдрөөр бус цаг, минутаар өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа эрчимтэй хөгжлийн цаг мөчид Та бид ажиллаж байна. Тиймээс ирээдүйг урьдчилан харж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, гүйцэтгэх үйл ажиллагаагаа оновчтойгоор төлөвлөх нь улс орны хөгжилд чухал ач холбогдолтой болно.

Монгол Улсын эрдэс баялагийн олборлолтоор дэлхийн хэмжээнд үзүүлэх нөлөө өсөж буй өнөө үед Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газрын Уул уурхайн газраас эрхлэн гаргасан “Монгол Улсын Уул уурхайн салбарын өнөөгийн байдал, эрдэс баялагийн түүхий эд, бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн судалгаа, дүгнэлт” сэдэвт судалгааны ажлын тайлан, дүгнэлтийг толилуулж байна.

Дэлхийн эдийн засагт уул уурхайн салбарын үзүүлэх нөлөө, хөгжлийн хандлага, Монгол Улсын хууль эрх зүйн орчин олон улсад хэрхэн үнэлэгдэж байгаа, голлох ашигт малтмалын үнэ ханшийн цаашдийн төлвийг олон улсад энэ чиглэлээр ажилладаг судалгааны байгууллагууд, эрдэмтэд, судлаачдын судалгаа, дүгнэлтүүдийг тусган тус газрын мэдээллийн санд тулгуурлан энэхүү ажлыг гүйцэтгэсэн болно.

Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсэн ерөөе!

АМГТХЭГ-ЫН ДАРГА



Ж.БИЛЭГСАЙХАН

Зохиогчид:

Судалгааны ажлын зөвлөх:

АМГТХЭГ-ын дарга

Ж.Билэгсайхан

Судалгааны ажлыг удирдсан:

АМГТХЭГ, УУГ, СССХ-ийн дарга

Б.Магванжав

АМГТХЭГ, УУГ-ийн ахлах мэргэжилтэн

О.Зоригт

Судлаж гүйцэтгэсэн:

АМГТХЭГ, УУГ, СССХ-ийн мэргэжилтэн

Б.Бямбадагва

АМГТХЭГ, УУГ, СССХ-ийн мэргэжилтэн

Н.Зоригтсайхан

Судалгааны ажлын талаарх санал хүсэлтээ дараах хаягаар ирүүлнэ үү.

Монгол Улс, Улаанбаатар 211238, Шуудангийн салбар 38,
АМГТХЭГ, Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Баруун жигүүр, АМГТХЭГ-ын Нэгдүгээр байр Уул уурхайн газар

Утас: 976-11-263709

Факс: 976-11-310041

E-mail: mrpam@mining.mn

Web page: <http://mrpam.gov.mn>

<http://b.byambadagva@mrpam.gov.mn>

1. Дэлхийн төмрийн хүдрийн үйлдвэрлэлийн өнөөгийн төлөв, хөгжлийн хандлага

1.1 Дэлхийн улс орны төмрийн хүдрийн үйлдвэрлэлт.

Аль ч улс орны хувьд төмрийн хүдэр нь стратегийн чухал ашигт малтмалын төрөлд тооцогддог. Техник тоног төхөөрөмжийг төмөргүйгээр төсөөлөхөд өнөөдөр бэрхтэй байна.

Төмрийн хэрэглээ ойрын жилүүдэд манай улстай хил залгаа ОХУ, БНХАУ-д төдийгүй дэлхийн хэмжээнд ч ихээхэн нэмэгдэж байна. Дэлхийн хэмжээнд төмрийн хүдрийг экспортлож байгаа 23, импортлож байгаа 33 орон байна. Үүнээс импортлон авч буй орнуудыг тэргүүлэгчид нь Хятад, Герман, Япон, БНСУ юм. Дэлхийн хэмжээнд төмрийн хүдрийн гол үнэ тогтоогч, төмрөөс хамааралтай орнуудын тоонд Европ тив, Хятад, Япон зэрэг улсууд орж байна. Манай хөрш 2 орон томоохон байр суурь эзэлдэг, цаашид импортын гол түнш орнуудаа түшиглэн төмрийн үйлдвэрлэлийг өндөр хурдацтай явуулах нь оновчтой юм.

Төмрийн хүдэр экспортлогч орнуудын нөөц багасаж, ирээдүйд хомсдол үүсвэл энэ төрлийн ашигт малтмалыг хуванцар, керамик сайжруулсан цаас зэргээр орлуулж болох ч төмрийг орлуулж болшгүй олон эд анги, барилгын материал зэргийн хэрэглээ байгаа нь энэ төрлийн ашигт малтмал ирээдүйд эрэлт хэрэгцээ ихтэй байсаар байхыг харуулж байна.

Түгээмэл ашиглагддаг үндсэн түүхий эд болох төмөр, зэс зэрэг металл эрдсийн баялгийг их хэмжээгээр олборлож шавхсаар байх юм бол ...хром, цагаан алт, хөнгөн цагаанаас өөр юм үлдэхгүй. Иймд байгалийн энэ баялгийг гамтай хэрэглэж, хэрэглэсэн металлыг дахин боловсруулах шаардлагатай байна. Металл дахин боловсруулах ажилд уул уурхай болон металл

боловсруулах үйлдвэрлэлийг татан оролцуулбал газрын доорхи баялаг шавхагдах, хүнд металл байгалийг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх боломжтой” гэсэн дүгнэлт гарч байна.

Азийн орнуудын төмрийн хүдрийн хэрэгцээг Австрали, Энэтхэг хангаж, гол худалдан авагч нь Хятад, Солонгос, Япон улс болж байна Европын орнуудынхыг ОХУ, Швед, Франц, ӨАБНУ хангаж, гол худалдан авагч нь Герман, Англи, Итали, Франц, Чех зэрэг улс байна.

Төмрийн хүдрийн ордыг дэлхийд хэмжээгээр нь:

1 тэрбум тонноос дээш нөөцтэй ордыг их том,


300 саяас 1 тэрбум тонн нөөцтэй том,

50-300 сая тонн нөөцтэйг жижиг ордод жишиг болгон тооцдог байна.

Монгол орны Дархан-Сэлэнгийн районы төмрийн хүдрийн ордын нөөц нь Том ордын ангилалд хамаарч байна.



Зураг-1 Дэлхийн төмрийн хүдрийн нийт нөөц




Зураг-2 2005 оны байдлаар Дэлхийн төмрийн хүдрийн олборлолтын гол эх үүсвэрүүд

Төмрийн хүдрийн дэлхийд томоохон нийлүүлэгчид нь Энэтхэг, Австрали, Бразили, Өмнөд африкийн улсууд бөгөөд дэлхийн хэмжээнд эхний аравт тооцогдох орнуудыг Зураг-1-д харууллаа.


Дэлхийн хэмжээнд жилдээ төмрийн хүдрийн экспортын хэмжээ дунджаар 440 -өөд сая тонн байдаг бөгөөд уг экспортын бүтээгдэхүүний 40 гаруй хувийг БНХАУ дангаараа хэрэглэдэг байна. Энэхүү хэрэглээ жил дараалан өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд цаашид ч өсөх хандлагатай байна.



Зураг-3 Дэлхийн төмрийн хүдрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл




Зураг-4 Ази, номхон далайн орнуудын төмрийн хүдрийн үйлдвэрлэл, хэтийн хандалаг



Зураг-5 Дэлхийн төмрийн хэрэглээ, үйлдвэрлэл, үнэ

Канадын MEG (Metall Economics Group)-ийн судалгааны төвөөс сүүлийн үед шинээр нээгдсэн ордуудын ойрын жилүүдэд ашиглалтад орох төлөвийг үндэслэн шинээр эхлэх төслүүдийн үйлдвэрлэлийн хэмжээг гаргажээ. Судалгааны явцаас харахад дэлхийн улс орнуудын үйлдвэрлэлт буурах хандлагатай байгаа нь газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбон тайлбарласан байна. Гэхдээ дан ганц газрын тосны үнийн өсөлттэй холбож болохгүй бөгөөд олон талын бэрхшээл урган гарч байгааг анхааралтай судалж үзэх шаардлагатай юм. Жишээ нь Бразили улс төмрийн хүдрийн үйлдвэрлэлтээр дэлхийд дээгүүр ордог бөгөөд түүнийгээ дагасан нийлүүлэлтийн явц нь хүндрэлтэй болж ирсэн. Энэ нь худалдан авагч компаниудын байршил нь тив алгасаж байгаагаас үүдэн гарч ирдэг байна. Үүнтэй холбоотойгоор өндөр зардалаар тээвэрлэлт явагдаж байна.

1.2 Дэлхийн улс орны төмрийн хүдрийн баяжмалын экспорт, импорт



Зураг-6

Дэлхийн томоохон төмрийн хүдэр экспортлогч орнууд БНХАУ-д экспортлосон төмрийн хүдрийн хэмжээ (тонноор)

Манай улсын хувьд Хятадын хар төмөрлөгийн үйлдвэрлэлийн хөгжлийн байдал чухал юм. Энэ том зах зээлийн өөрчлөлтийг бид анхааралтай судлах учиртай.

БНХАУ нь дэлхийд хамгийн их төмрийн хүдрийн нөөцтэй орнуудын тоонд ордог. БНХАУ-ын албан ёсны статистик мэдээгээр тус улсад төмрийн хүдрийн орд, илэрц 1940 байдаг ба 99 нь томоохон ордод тооцогддог бөгөөд тэдгээрийн төмрийн хүдрийн нийт нөөц нь 2007 оны байдлаар 21 тэрбум гаруй тонноор хэмжигдэж байна.

1.3 Дэлхийн төмрийн хүдрийн эрэлт нийлүүлэлт, үнийн хэтийн төлөв

Металлын үнийн хэлбэлзэл нь гурван гол хүчин зүйлээс хамаардаг.

Үүнд:

1. Эрэлт нийлүүлэлт, зах зээлийн тэнцвэр болон агуулахын нөөц.
2. Дэлхийн аж үйлдвэрлэл
3. Америк долларын индекс

Металлын эрэлт нь дэлхийн аж үйлдвэрийн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн мөчлөгөөс хамааран ихээхэн хэлбэлздэг бол нийлүүлэлт нь ихэвчлэн

тогтвортойгоор өсч байна. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэл, хэрэглээний зөрүү буюу зах зээлийн илүүдэл, хомсдолын өөрчлөлт нь металлын үнэ бүрдэлтэд нөлөөлдөг. Хэрэв эрэлтийн мөчлөгийн хэлбэлзэл нь нэг хязгаарт тэмүүлбэл тухайн зах зээл дээр үнийн тэнцвэр тогтоход бэрхшээлтэй юм. Энэ тохиолдолд үнэ болон нийлүүлэлт нь зах зээлийн тэнцвэрийн түвшинд хэлбэлзэж байвал илүүдэл, хомсдол болон агуулахын нөөцийн хэмжээ өөрчлөгдөж эхэлдэг.

Дэлхийн аж үйлдвэрлэлийн өсөлт нь металлын үнэ бүрдэлтэд нөлөөлж буй хоёр дахь хүчин зүйл юм. Лондонгийн металлын биржийн үнийн загварт эрэлтийн хэлбэлзлийг дэлхийн аж үйлдвэрлэлийн мөчлөгийг суурь болгон тодорхойлж байна. 1980 оны эцэс, 1998 оны эхэн, 2008 оны эцэс хүртлэх үед дэлхийн бизнесийн мөчлөг дунджаар 5 жилээс 3 жил хүрэхгүй болж буурсны зэрэгцээ хэлбэлзэл нь бага зэрэг өссөн юм. Эдгээр нь дэлхийн аж үйлдвэрлэлийн өсөлтийн хурдсалт, удаашралт цаашилбал төмрийн эрэлтийн мөчлөгийн хэлбэлзэл, түүний өсөлтөд нөлөөлжээ. Иймээс дэлхийн зах зээлийн төлөв хандалга нь металлын үнэд ихээхэн нөлөөлдөг нь харагдаж байна. Мөн түүнчлэн Монгол улсын хувьд сүүлийн жилүүдэд төмрийн хүдэр, баяжмал экспортлож байгаагийн хувьд үнийн хэлбэлзэлийг маш олон талаас нь харж ашгийн өндөр төвшинд барьж байх явдал хэрэгтэй юм.

Ихэнх томоохон бирж дээрх металлын гүйлгээ нь ам.доллараар илэрхийлэгддэг. Хэдийгээр ам.доллар нь бусад валютуудын адилаар металлын үнийг тодорхойлох шууд буюу абсолют хэмжүүр биш боловч металлын үнийг хэмжих нэгж нь ам.доллар байгаагаас валютын ханшийн хэлбэлзэл нь төмрийн хүдэрийн үнийн өсөлт, бууралтад нөлөөлж байна. Тухайлбал ам.долларын ханш унахад металлын үнэ өснө. Өөрөөр хэлбэл ам.доллар болон металлын үнэ хоорондоо сөрөг хамааралтай юм.

Ам. Долларын ханшийг тодорхойлохдоо харьцангуй давуу чанарын индексийг ашигладаг ба долларын бусад валюттай харьцах индексийг долларын ханшийн хэлбэлзлийн дээд доод хязгаарыг тодорхойлоход

хэрэглэдэг юм. Үүний зэрэгцээ металлын үнийг тооцоолохтой холбоотойгоор үнийг тодорхойлогч дөрөв дэх хүчин зүйл болох хүүгийн түвшнийг авч үздэг.

Зах зээл дээрх металлын үнийн хэлбэлзлийг тодорхойлохдоо уламжлалт болон орчин үеийн чиглэлийг авч үзэж байна. Уламжлалт чиглэл нь зах зээлийн тэнцвэр, илүүдэл, хомсдлыг чухалчилдаг бол орчин үеийн чиглэл нь аж үйлдвэрлэл буюу эрэлтийн хүчин зүйлсийг судалгааны гол цөм гэж үздэг.

Сүүлийн жилүүдэд металлын үнийн хэлбэлзлийг аж үйлдвэрлэлийн өсөлтөөр тодорхойлох нь илүү давамгайлах болжээ. Гэвч энэхүү аргын сул тал нь зах зээл дээрх металлын үнийн бодит түвшинг бус ерөнхий мөчлөгийг нь тодорхойлоход оршиж байна. Тэгвэл энэхүү хоёр үзэл баримтлал, чиглэлийг хослуулан авч үзсэнээр дэлхийн аж үйлдвэрлэлийн өсөлт глобал шинж чанартай болдог байна. Үүнээс гадна зах зээл дахь илүүдэл болон металлын үнийн хоорондын хамаарлыг дараах загвараар тайлбарлаж болно.

Энэ загвараар дэлхийн аж үйлдвэрлэлийн хурдацтай өсөлт болон биржийн агуулахын нөөцийн бага төвшин нь металлын үнийг хамгийн өндөр түвшинд хүрч өсөхөд нөлөөлдөгийг илэрхийлнэ. Эсрэгээр нь бирж дэх металлын агуулахын нөөц ихсэхэд, металлын үнэ унах болно.

Хэрэв агуулахын нөөц 100 мянган тонн, IP-ийн өсөлт 6-7% байвал зэсийн зах зээлийн үнэ 80\$-120\$ байх жишээтэй. Харин нөөцийн хэмжээ өөрчлөгдөөгүй байхад IP-ийн өсөлт 3% болж буурахад металлын үнэ хэрхэн унахыг доорх загвараас харж болно. Энэ уламжлалт чиг хандлага нь металлын үнэ бүрдэлтэд тэр бүр шууд буюу хүчтэй нөлөөлдөггүй болохыг илэрхийлж болно. Өөрөөр хэлбэл уламжлалт хандлагын зарчмаар тэнцвэржүүлэх хандлага гарвал энэ маань тэр бүр зах зээл дээрх үнийн хэлбэлзлийг тодорхойлохоор чиг хандлага болж чаддаггүй байна.

Мөн түүнчлэн биржийн агуулахын нөөц болон IP-ийн өсөлт нь эрсэдлийн шинжээчид болон зах зээл судлаачдад ирээдүйн 24 сар хүртэл металлын прогноз үнийг тодорхойлох чухал хүчин зүйл болж хэрэглэгддэг. Дээрхээс харахад агуулахын нөөц зэсийн үнэд хэрхэн нөлөөлдөгийг харлаа.

Зах зээлийн тэнцвэрт байдлаас хамаарч төмрийн хүдрийн үнэ өөрчлөгддөг болохыг дээхэн үед харан авч шинждэг байсан бол орчин үеийн эдийн засагчид үйлдвэрлэгчид, эрэлтийн хуулийг чухалчилдаг болжээ.

Мөн түүнчлэн сүүлийн жилүүдэд дайнтай холбоотойгоор зарим металл, голлох байр суурь эзэлсэн төмрийн үнэ хий хөөрөгдөн өсч ам.долларын евро, фунт, стерлинг, иентэй харьцах ханш унаж эхэлсэн. Улс төрийн эрс шийдвэр, дайн мөнгөний ханшийн уналтын үед хүмүүс эрсдэлээс сэргийлж, хэзээд мөнгөнд хөрвөх чадвартай үнэт металл хэлбэрээр мөнгийг хадгалах сонирхол давамгайлна. Гэвч тэд зах зээлийн нөхцөл байдлыг харгалзаж үзэлгүй хайхрамжгүй дүгнэлтэд хүрч байжээ. Ам.долларын бусад гол валюттай харьцуулсан индекс 2008 оны 3-р сарын үед 12%-иар буурсан бөгөөд цаашилбал шинэ тэнцвэр тогттол буурах төлөвтэй байна. Энэ хугацаанд евротой харьцах ханш л гэхэд 10%-иар өссөн байна. Харин өмнөх саруудад гаргасан шийдвэрээр Европын Төв Банк бүс нутгийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээлийн хүүг бууруулах нь зайлшгүй болохыг баталж, дараа сарын зээлийн хүүг 2,5% хүртэл бууруулсан нь еврогын ам.доллартай харьцах ханшийн өсөлтийг бага зэрэг удаашруулсан байна. Цаашид ам.долларын ханш эрчимтэй унаж эхэлбэл энэ нь төмрийн хүдэрийн үнэд сөргөөр нөлөөлж болох юм. Гэвч зарим судалгааны байгууллагууд ам.долларын ханшаас гадна бусад хүчин зүйлүүдийг үндэслэн төмрийн хүдэрийн үнэ энэ оны эцсээр 110-125\$/тонн –д хүрнэ гэсэн магадлал гаргасан байна.

Дэлхийн хөгжлийн хандлага, зах зээлийн төлөв байдал, улс төрийн орчин зэргийг харгалзан үзээд банк, санхүүгийн болон судалгааны байгууллагууд төмрийн хүдэрийн үнийн хандлагыг тодорхойлж байна. Иймээс төмрийн хүдэрийн үнэ бүрдэлтэд нөлөөлөх хүчин зүйлүүдийг сайтар судлан байж ерөнхий чиг хандлагыг нухацтай авч үзэх нь зүйтэй юм.

Монгол улсад нийгмийн дэд бүтэц хүрэлцээтэй хөгжөөгүй, санхүү-эдийн засгийн боломж муутай байгаа зэрэг үндсэн шалтгаануудаас болоод өндөр хүчин чадалтай орчин үеийн металлургын үйлдвэр байгуулах боломж


хязгаарлагдмал хэвээр байна. Үүнээс гадна дэлхий нийтийн дунд төмрийн үнийн өсөлтийг ирээдүйд хурдацтайгаар өснө гэсэн таамаглал байна. Энэ нь сүүлийн жилүүдэд Төмрийн хүдрийн гол худалдан авагч улс БНХАУ эдийн засгийн өсөлт, аж үйлдвэржилтийн түвшин нь эрчимтэй хөгжиж байгаагийн илрэл юм.

БНХАУ-д ойролцоогоор 490 дунд хэмжээний орд байдаг бөгөөд тэдгээрийн нөөц нь 10-аас 100 сая тонны хооронд хэлбэлздэг. Үлдсэн ордууд нь жижигт тооцогддог. БНХАУ-ын төмрийн хүдрийн нийт нөөц нь дэлхийн батлагдсан нөөцийн 9.6%-тай тэнцдэг юм. Ийм их хэмжээний нөөц байгаа ч Хятадын төмрийн хүдэр нь дунджаар зөвхөн 33%-ийн буюу бага агуулгатай бөгөөд энэ нь тэдний хувьд гол сул тал болж байна. Үүнээс гадна 1700 гаруй ордыг ашиглахгүй байгаа нь хөнгөн цагаан болон фосфор зэрэг дагалдах элементүүдийн агуулга өндөр тул хүдрийн чанарт нөлөөлдөгөөс шалтгаалж байна. Төмрийн хүдрийн ордуудын ихэнх буюу ойролцоогоор 90% нь Хятадын зүүн болон зүүн хойд мужуудад оршдог бол (улс орны нийт нөөцийн 50% нь зөвхөн Хэбэй ба Ляонин гэдэг хоёр мужид оршиж байна). Зураг-3-аас харахад Дэлхийн хүдрийн хэрэглээ БНХАУ-аас шууд хамааралтай байна.

Сүүлийн жилүүдэд БНХАУ хар төмөрлөгийн тэргүүлэх үйлдвэрлэгч болсон боловч, хүдрийн агуулга бага учраас металлын үйлдвэрлэл маш бага түвшинд байсан. 2003 оны жилийн эцсийн байдлаар БНХАУ ойролцоогоор 128 сая тонн хүдэр олборлож байсан бөгөөд энэ нь дэлхийн олборлолтын ойролцоогоор 13%-ийг эзэлж байсан байна. Хятадын хамгийн том ордууд болох 16 уурхайд хүдрийн нийт олборлолтын хагас хувь нь ногддог бол, үлдсэн хувийг 1000 гаруй жижиг, дунд уурхайнууд үйлдвэрлэдэг бөгөөд тэд жилд дунджаар 50 мянгаас 1 сая хүртэл тонн хүдэр үйлдвэрлэдэг байна.

Хятадын өнгөт металлын үйлдвэрийн салбарт саяхан хийгдсэн бүтцийн өөрчлөлтийн үр дүнд үйл ажиллагааны орлого багатай олон жижиг уурхай хаагдахад хүрсэн. Энэ арга хэмжээний үр дагаврыг албан ёсоор хараахан дүгнээгүй байгаа боловч жижиг уурхайнууд хаагдсаны улмаас

үүссэн хар төмөрлөгийн нийлүүлэлтийн хомсдолыг богино хугацаанд импортоор хангаж эхэлсэн болно. 2002 оноос хойш БНХАУ дэлхийд хар төмөрлөгийн хамгийн том импортлогч болон хувирсан. Энэ нь байгаль орчныг хамгаалах дэлхийн улс орнуудын бодлоготой нийцсэн алс хэтийн үр ашигтай алхам болж байна.



Зураг-7 БНХАУ ба Дэлхийн бусад орнуудын төмрийн хүдрийн жилийн дундаж хэрэглээ

Иймд Хятадын хөрөнгө оруулалттай хоцрогдсон технологитой төмрийн үйлдвэрүүдийг аль болох өөрийн оронд нэвтрүүлэхгүй байх мөн дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн орчин үеийн технологийг ашиглах нь зүйтэй юм.

Хар төмөрлөгийн нөөцийн хомсдолын бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд хар төмөрлөгийн томоохон компаниудтай урт хугацааны тогтвортой хугацааны гэрээнүүдийг байгуулсан байна. ВНР Billiton 3 томоохон хар төмөрлөгийн үйлдвэртэй бөгөөд нийтдээ 420 сая тонн хүдэр нийлүүлэх 12 жилийн, Rio Tinto 400 сая тонн хүдэр нийлүүлэх 20 жилийн, Fortescue Metals

Group (нийтдээ 364 сая тонн хүдэр нийлүүлэх) болон CVRD (135.7 сая тонн нийлүүлэх 20 жилийн) гэрээг БНХАУ-тай тус тус байгуулсан байна.




Иш татсан: ThyssenKrupp Stahl AG

Зураг-8 Төмрийн хүдрийн далайгаар тээвэрлэсэн худалдааны урсгалууд
Сүүлийн 5 жилийн биржийн үнэ

Хүснэгт-2

Төмрийн хүдэр/жил		2003	2004	2005	2006	2007
Бразил	ам.доллар	31.95	37.90	65.00	77.35	83.65
Австрали	ам.доллар	30.83	35.99	61.72	73.45	82.00
Мавритани	ам.доллар	30.30	41.35	70.92	78.15	83.95


Дэлхийд ган үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч ВНР компаний судалгаа дэлхийн ган болон ширэм үйлдвэрлэлийн хэтийн төлөвийг үзүүлсэн байна.



Зураг-9 Дэлхийн төмрийн хүдрийн хэрэглээний ирээдүйн төсөөлөл

ВНР компанийн судалгаагаар дэлхийн төмрийн хүдрийн хэрэглээ 2010 он хүртэл тогтмол өсөж 1100 сая тоннд хүрэх ажээ. ВНР компаниас гаргасан судалгааны дүн манайд гүйцэтгэсэн судалгааны дэлхийн төмрийн хүдрийн хэрэглээ, нийлүүлэлтийн хэтийн төлөвтэй ойролцоо байгаа юм.

Лондонгийн металлын бирж дээрхи төмрийн хүдрийн 2006 оны 1-сараас 2008 оны 8-р сар хүртэлхи үнийг Зураг-9-д үзүүллээ. Дэлхийн зах зээл дэхь нэг тонн төмрийн хүдрийн үнэ 2006 онд тогтмол 62 ам доллар байснаа 2007 оны эхний улиралд 74 ам доллар болж өсөөд түүнээс хойш 81 ам долларт хүрээд байна. Ерөнхийд нь авч үзвэл төмрийн хүдрийн үнэ тогтмол өсөх хандлага ажиглагдаж байгаа юм.



Зураг-10 Дэлхийн төмрийн хүдрийн зах зээлийн үнэ /2006-2008/



Зураг-11 Дэлхийн төмрийн хүдрийн дундаж үнэ

“Төмрийн хүдэр, баяжмал”-ын дэлхийн экспортын хэмжээ 2005 онд 506503951.0 тонн буюу борлуулалт нь 27873514.0 мянган америк долларт

хүрчээ. Олон улсын худалдааны төв (ИТС)-д дэлхийн 60 гаруй орноос цуглуулан нэгтгэсэн багц мэдээгээр дэлхийн экспорт 2001-2005 онуудад үнийн дүнгээр 33 хувиар, биет хэмжээгээр 2 хувиар тус тус өсчээ. 2005 онд өмнөх оныхоос үнийн дүнгээр 59 хувиар өссөн ба өмнөх онтой нь харьцуулахад 2005 оны байдлаар, төмрийн хүдэр, баяжмалын дэлхийн экспортын тоо хэмжээ нь 15.5 хувиар буурчээ. 2005 онд манай улс төмрийн хүдэр, баяжмалын экспортоор дэлхийд 35 дугаар байр эзэлжээ. Төмрийн хүдэр, баяжмалын дэлхийн экспорт 2001-2005 онуудад жилд дундажаар, төмрийн хүдэр, баяжмалын дэлхийн импорт үнийн дүнгээр 37 хувь, биет байдлаар 10 хувиар нэмэгджээ. 2005 оноос дэлхийн төмрийн хүдэр, баяжмалын импортод БНХАУ 45, Япон 14, ХБНГУ 5, БНСУ 5, Итали 3, Франц 2, Их Британи 2, Тайван 2, ОХУ 2, Нидерланд 2, АНУ 1, Канад 1 хувийг тус тус эзэлжээ. БНХАУ, Япон, ХБНГУ, БНСУ, Итали улс 2005-2006 онд төмрийн хүдэр, баяжмал импортлогч эхний таван орон болов. БНХАУ 2005 онд 275, 2006 онд 326 гаруй сая тонн төмрийн хүдэр, баяжмал импортоор авч, тухайн импортлогч орнуудын тэргүүн эгнээнд явж байна. БНХАУ-ын төмрийн хүдэр, баяжмал импортын жилийн дундаж өсөлт нь 2001-2005 оны хооронд үнийн дүнгээр 74 хувь, биет хэмжээгээр 32 хувьд хүрчээ. Мөн 2005 онд өмнөх оныхоос 45 хувиар өсчээ. БНХАУ-ын төмрийн хүдэр, баяжмалын импортын дүнд 2005 оноос Австрали улс 34, Энхэтхэг 28, Бразил 21, ӨАБНУ 4, ОХУ 2, Канад 2, Казахстан 1 хувийг, харин Монгол улс 0.05 орчим хувийг тус тус эзэлж байна.

2. Монгол орны төмрийн хүдрийн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага

2.1 Монгол Улсын төмрийн хүдрийн нөөц, ашиглалт

Манай орны хувьд энэ төрлийн ашигт малтмалын олборлолт, боловсруулалтанд анхааралтай хандаж төрийн бодлогоор зохицуулах зайлшгүй шаардлага урган гарч байна.

Монгол улс төмрийн ордоор баялаг орон. Монгол Улсын ашигт малтмалын нөөцөд бүртгэгдсэн төмрийн хүдэр 453 сая,тн юм.

Сэлэнгэ-Дарханы районы төмрийн хүдрийн орд газруудын тогтоогдсон нөөц, агуулга чанарын үзүүлэлтүүд

Хүснэгт-3

д/д	Ордын нэр	Нийт нөөц Сая тонн	Дундаж агуулга		
			Fe	S	P ₂ O ₅
			%		
1.	Төмөртэй	229,5	50,9	1,24	0,05
2.	Баянгол	110,1	49,8	3,11	0,20
3.	Хуст уул	23,5	51,8	2,3	0,04
4.	Төмөр толгой	27,0	54,3	1,26	0,09
Нийт		390,3	-	-	-

Хүснэгт-3 аас харахад Монгол орны төмрийн хүдрийн нөөц эдийн засгийн хувьд уул уурхайн салбарт өр өгөөжээ өгөх бүрэн бололцоотой юм.

Монгол орны төмрийн хүдрийн нөөцийг түшиглэсэн боловсруулах үйлдвэр барих явдал нь нарийн төвөгтэй боловч шийдвэрлэх ёстой асуудал юм. Ирээдүйд Төмөртэй, Төмөр толгой, Баргилт зэрэг ордыг түшиглэн ган цувималын үйлдвэр байгуулах хэрэгтэй. Төмөртэйн голын ордын хүдэр дэх төмрийн агуулга 30-69%, хорт хольцын агуулга хүхэр 0.3%-иас бага, зэс 0.2%, мышьяк 0.07%, цайр , хар тугалга 0.08%-иас ихгүй байх ба ядуу агуулгатай шигтгээлэг хэлбэрээр агуулагдах төмөр 20-30%-ийг эзэлж байна. Иймээс Төмөртэйн ордод хийсэн судалгааны үр дүнгээс харвал технологийн сонголтыг зөв ашиглавал 76-97% металл авалттай байх боломжтой гэсэн дүгнэлт гарч байна. Тухайн ордын хүдэр нь маш сайн

судлагдсан 1981 оноос хойш ГТЛ, БНХАУ-ын Бугатын төмөрлөгийн үйлдвэрийн лаборатори, Монголын Геологийн албаны лаборатори, Эрдэс судалгааны “Эрд-элит”ХХК-ний лабораториудад баяжигдах шинж чанарын судалгааны туршилтууд хийгдсэн байна. Судалгааны үр дүн төмрийн хүдрийн баяжмал ирээдүйд Монгол орны экспортын салашгүй нэг хэсэг болох бололцоотойг харуулж байна. Хагас баяжуулсан төмрийн хүдрийн экспорт бий болж 2004 онд 30 гаруй мян. тонн, 2005 онд 130 мян. тонныг Сэлэнгийн Хустайн уурхайгаас экспортод гаргасан юм. 2005 оны 9 дүгээр сард Төмөртийн овооны орд дээр байгуулсан баяжуулах үйлдвэрийг ашиглалтанд оруулсан ба 24 мян.тонн цайрын баяжмалыг туршилтаар экспортолсон байна. 2006 онд 105,8 мян.тонн, 2007 онд 132.3 мян.тонн цайрын баяжмал тус тус үйлдвэрлэжээ. 2006 оны эхний 5 сард 28.2 мян.тонн баяжмал үйлдвэрлэж экспортлосон байна.

Манай орны гол нэр төрлийн металлын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Хүснэгт-4

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2005	2006	2007
Зэсийн баяжмал %	мян.тн	515.8	537.7	543.1
Төмрийн хүдэр %	мян.тн	167.7	180.0	265.1
Цайрын баяжмал %	мян.тн	22.8	109.9	154.7

Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших Баргилтын төмрийн хүдрийн орд газар дээр 2005 оны 7-р сараас БНХАУ-ын 100%-ийн хөрөнгө оруулалттай Тун Синь ХХК уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 2006 оны 2-р хагасаас ашиглалт, олборлолтын ажилаа явуулж төмрийн хүдрийн баяжмал боловсруулан гаргаж Хятад улс руу экспортлож байна. Баргилтын уурхай 2007 онд 113.6 мян.тн төмрийн хүдэр олборлон боловсруулж, 49,7 мян.тн төмрийн хүдрийн 47,7-55,0 хувийн агууламжтай баяжмал үйлдвэрлэж, Монгол улсын төсөвт ашигт малтмалын нөөцийн ашигласан татварт 170,9 сая төгрөг төлсөн байна.

Цаашид Баргилтын уурхай нь жилд нийт 700 мян.м³ хөрс хуулж, 200 мян.тн хүдэр олборлон баяжуулж, хаягдлыг 5%-иар, бохирдолыг 7%-иар бууруулах, борлуулалтын нийт орлого 5 880,0 сая төг байхаар төлөвлөжээ. Энэ бүхнээс харахад Баргилтын уурхай 10 жилийн хугацаанд төмрийн хүдрийн баяжмал тогтмол экспортод гаргах бүрэн боломжтой юм.

Баргилтын уурхайн хүдрийн нөөц, агуулга

Хүснэгт-5

Нөөц	Хүдэр мян.тн	Fe,%	P,%	S,%
Геологийн	245,95	37.66	0,05	0.05
Ашиглалтын	250,0	35.2	0.05	0.05

2.2 Төмрийн хүдрийн хайгуул, олборлолтын байдал, тусгай зөвшөөрлийн талаархи мэдээлэл

2008 оны 3 дугаар сарын байдлаар төмрийн чиглэлээр хайгуул болон олборлолт явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн судалгааг хүснэгт №6-т үзүүллээ.

Хүснэгт-6

	Нийт ашиглалтын тусгай зөвшөөрөл	Төмрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл	Хайгуулын тусгай зөвшөөрөл
Тусгай зөвшөөрлийн тоо	1024	23	5
Тусгай зөвшөөрлийн галбай /га/	409852.1	8154	3425

	Ашиглалтын тусгай зөвшөөрөл
Дотоодын аж ахуйн нэгж	10
Гадаадын 100% хөрөнгө оруулалттай а.а.н	9
Хамтарсан	2

	Үйл ажиллагаа явуулж байгаа	Техник, технологийн туршилтанд байгаа
Хятад	нэг	хоёр
Монгол	нэг	хоёр

2.3 Монгол орны төмрийн хүдрийн ордуудын эдийн засгийн орчин

Манай улс БНХАУ-д төмрийн хүдэр, баяжмал экспортолж байна. 2005 онд экспортолсон нэг тонн төмрийн хүдэр, баяжмалын дэлхийн дундаж үнэ 55 америк доллар байхад Монголоос экспортолсон нэг тонн төмрийн хүдэр, баяжмалын гаалийн дундаж үнэ 27 орчим америк доллар байв. Монгол улсаас экспортолсон нэг тонн төмрийн хүдэр, баяжмалын гаалийн дундаж үнэ 2002 онд 6.7 америк доллар байсан бол 2006 онд 36.7 америк доллар болжээ. Монголын экспортын нэг тонн төмрийн хүдэр, баяжмалын гаалийн дундаж үнэ нь 2004-2006 онуудад жилд дундажаар 42 хувиар өсчээ. 2007 оны эхний найман сард монголоос экспортолсон нэг тонн төмрийн хүдэр, баяжмалын гаалийн дундаж үнэ 51.9 америк доллар болж, 2007 оны эхний зургаан сарын дундажаас 6.9 америк доллараар өсчээ. Монголын төмрийн хүдэр, баяжмалын экспорт 2005 оны байдлаар төмрийн хүдэр, баяжмалын дэлхийн экспортын үнийн дүнд 0.017 хувийг эзэлж байв.

Экспортын үнийн дүнд төмрийн хүдэр баяжмалын экспорт 2006 онд 0.7 хувь, 2007 оны эхний найман сард 0.3 хувийг тус тус эзэлж байна.

Төмрийн хүдэр, баяжмалын экспортын дүн 2006 онд 11.5 орчим сая америк доллар болж, өмнөх оныхоос 2.4 дахин нэмэгджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2007 оны эхний найман сард манай төмрийн хүдэр, баяжмалын экспортын дүн 3.6 орчим сая ам.доллараар буюу 48 хувиар буурчээ. Төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээ 2006 онд 312.5 орчим мянган тоннд хүрч, өмнөх оныхоос 75.7 хувиар нэмэгдсэн.

Хэтийн төлөвтэй төслүүд

Хүснэгт-7

Д/д	Ордын нэр	Ашигт малтмалын төрөл	Нөөц
1	Хуст уул	Төмөр	4.4 сая.тн Fe
2	Цав	Хар тугалга, Цайр	3.5 сая.тн хүдэр, 226.2 мян.тн Pb, 123.3 мян.тн Zn
3.	Баргилт	Төмөр	31 сая.тн Fe
4.	Төмөртэй	Төмөр	229.3 сая.тн Fe
5.	Оюу толгой	Зэс, Алт	24 сая.тн Cu, 720 тн Au
6	Цагаан суварга	Зэс, Молибден	240.0 сая.тн хүдэр, 1.3 сая.тн Cu, 48.2 мян.тн Mo
7.	Улаан	Хар тугалга, Цайр	14.8 сая.тн хүдэр, 186.4 мян.тн Pb, 245.8 мян.тн Zn
8.	Мардай	Уран	924.6 мян.тн хүдэр, 1104 тн U
9.	Таван толгой	Нүүрс	7.0 сая.тн

2007 оны эхний найман сард 74300 тонн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 64 хувиар багасч, экспортын тоо хэмжээний бууралтад зарим ордуудын тусгай зөвшөөрлийг цуцлан дотоодын үйлдвэрлэгчдэд шилжүүлсэн нь нөлөөлөв. Монголын металл бэлдэц, цувимлын үйлдвэрлэлтийн байдал сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж, судалгааны ажил нь ч үр дүнгээ өгсөөр байгаа билээ.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд төмрийн үйлдвэрлэлт 1994 онд 0.3 хувийг эзэлж байсан бол 2006 онд 3.7 хувийг эзлэх болжээ. Манай улсад сүүлийн жилүүдэд барилгын үйлдвэрлэлийн өсөлтөөс хамаарч металл бэлдэц, цувималын эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байна. Төмрийн үйлдвэрлэлтийн биет үзүүлэлтийг авч үзвэл, 2001-2006 онуудад металл бэлдэц 10-аас 70 мянган тонн, металл цувимал 7-оос 54 мянган тоннд хүрчээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2007 оны эхний 8 сард биет хэмжээгээр металл бэлдэц 19.2 хувиар, металл цувимал 29.7 хувиар нэмэгджээ.

Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр /ДХТҮ/ нь төмрийн хаягдлыг ашиглаж жилд 150 мян.тн төрөл бүрийн цувимал үйлдвэрлэх хүчин чадалтай боловч одоогийн байдлаар манай улсын хаягдал төмрийн нөөц үндсэндээ шавхагдсан, импортын хаягдал төмөр өндөр үнэ, зардалтайгаас ашиггүй ажиллаж байна.

Энэ нь хаягдал төмрийн нийлүүлэлт/худалдан авалт жил бүр буурч, (тухайлбал 2007 онд өмнөх оныхоос 11.6 орчим мянган тонноор буурах хандлагатай), сүүлийн жилүүдэд хаягдал хар төмрийг их хэмжээгээр экспортод гаргаж байсантай, тэрчлэн хятадын хөрөнгө оруулалттай төмрийн үйлдвэрүүд хямд үнэтэй, чанар муутай төмөр утас, арматур гаргаж нийлүүлсэнтэй шууд хамааралтай байсан.

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн хүч чадлын ашиглалт нь 2005-2007 онд дараах байдалтай байв. Үүнд: Металл бэлдэцийн үйлдвэрлэлтийн хүч чадлын ашиглалт нь 2005-2006 онд 60-64 хувьд хүрчээ. Гэвч 2007 онд өмнөх оныхоос 8.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Металл цувималын үйлдвэрлэлтийн хүч чадлын ашиглалт нь 2005-2006 онд 36-54 хувьтай байсан бол 2007 онд өмнөх оныхоос 8.5 хувиар буурсан байна.

Иймд ДХТҮ-ийн найдвартай ажиллагааг хангах эн тэргүүний зорилт нь түүхий эдээр хангах асуудлыг шийдвэрлэх явдал болно.

Уг асуудлын хүрээнд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК нь ойрын жилүүдэд хаягдал төмөр дахин боловсруулах, төмрийн хүдрийн хайгуул-ашиглалтын лицензтэй байх, төмрийн хүдрээс ширэм, ган гарган авах, багаж хэрэгслийн ган, болд, чанаржуулсан ган, зэвэрдэггүй ган, хуудас, суурь машины, эд анги, бусад шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх дэвшилтэт технологийг ашиглахаар төлөвлөж байна. Энэ чиглэлээр төрөөс татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Ойрын ирээдүйд төмрийн хүдэр олборлон боловсруулах үйлдвэрүүд, ган төмөр, түүгээр хийсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжигч шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн

цогцолбор байдлаар “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-ийг хөгжүүлэх боломжтой юм.

Хэрвээ Төмөртэйн төмрийн хүдрийг баяжуулж төмрийн баяжмалыг коксждоггүй нүүрсээр шууд ангижруулах технологиор /Direct Redution/ сархиараг буюу түүхий төмөр /Sponge iron/ үйлдвэрлэх судалгаа, техник эдийн засгийн тооцоо боловсруулан түүхий төмрийн үйлдвэрийг Төмөртэйн орд газрыг түшиглэн барьж байгуулах нь оновчтой юм.

Мөн түүнчлэн БНХАУ-ын төмөрлөгийн үйлдвэрлэлийн томоохон төвүүд манай хилийн ойролцоо, төмөр замын дагуу байршдаг нь манай улсын төмрийн үйлдвэрлэлд онцгой ач холбогдолтой байна. Төмөртэйд хамгийн ойр Бугатын төмөрлөгийн үйлдвэрт гэхэд 1500 км төмөр замаар тээвэрлэн хүргэх тээвэрлэлт, ачилт буулгалт болон бусад зардлыг нэмэн тооцоход үйлдвэрт хүрэх үнэ нь бусад импорт, тухайлбал Энэтхэгийнхээс хавьгүй доогуур байна.

Бугатын төмөрлөгийн үйлдвэр нь жилд 5 сая тн ган үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд төмрийн цэвэр хүдэр гэхэд л 3.5 сая тн-ыг гаднаас импортоор авах шаардлагатай байгаа юм. Үүнээс гадна Бугатын үйлдвэр нь Хятадын Засгийн газраас татаас авах эрхтэй бөгөөд, өртөг зардал бууруулах, үр ашиг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

Баянголын төмрийн хүдрийн орд нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Дулаанхааны төмөр замын өртөөнөөс 80 км, манай орны томоохон төв (төмөрлөгийн үйлдвэр бүхий) Дархан хотоос 120 км-ийн зайд, Дархан Бугантын 110 квт-ын өндөр хүчдэлийн шугамаас 7-8 км зайд, эдийн засаг, дэд бүтцийн тааламжтай нөхцөлд оршдог.

Баянголын ордын нөөцийн хэмжээ

Хүснэгт-8

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон үзүүлэлт		
			Баруун биет	Зүүн биет	Нийт
1	Төмрийн хүдрийн нөөц	сая.тн	24.02	55.64	79.66
2	Хүдэр дэх төмрийн агуулга	%	46.5-52.9	49.11	49.5
3	Хүхрийн агуулга	%	0.1-1.6	1.08	0.92
4	Фосфорын агуулга	%	0.05-0.12	0.03	0.06

Баянголын уулын үйлдвэр нь жилд 143763.6 сая.төг-ийн бүтээгдэхүүн гаргахаар тооцжээ. Үйлдвэрийг байгуулахад 181263.1 сая.төг-ийн хөрөнгө оруулалт хэрэгтэй ба жил бүрийн ашиглалтын зардал нь 119223.9 сая.төг болно. Энэ тохиолдолд үйлдвэр 11.6 жилийн хугацаанд хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн төлнө гэсэн тооцоо байна. Энэхүү Баянголын уурхайг 2008 оноос ашиглалт явуулахаар бэлдэж байгаа бөгөөд ирээдүйн монгол орны төмрийн хүдрийн салбарт ихээхэн хувь нэмэр оруулах боломжтой юм.

Монгол орны боловсруулах аж үйлдвэрийн бүтэц, 2007 онд

хүснэгт-9

№	Бүтээгдэхүүн	ЭЗЛЭХ ХУВЬ
1	Төмрийн үйлдвэрлэл	27.30%
2	Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	3.90%
3	Мод, модон эдлэл үйлдвэрлэл	0.30%
4	Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	0.60%
5	Нэхмэлийн үйлдвэрлэл	25.10%
6	Бусад	42.80%

Хүснэгт 9-өөс харахад сүүлийн жилүүдэд төмрийн боловсруулах үйлдвэр аж үйлдвэрлэлийн салбарт хурдацтай гарч ирж буйн нэгэн тод жишээ юмаа.


Төрийн бодлого зохицуулалтын хүрээнд дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн техник-эдийн засгийн үндэслэл, төсөл, түүний зорилго, зорилт, стратегийн төлөвлөсөн арга хэмжээнүүд, гүйцэтгэлийг нь хянах шалгуур үзүүлэлт, стандартын шаардлагыг ил тод хэрэгжүүлэх чиглэл гарч байна.

Дээрхи зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэх, гарч болозошгүй сөрөг үр дагавар, хохирлыг арилгах зорилгоор дараах асуудлуудыг судлах шаардлагатай байна.

- Манай улсын нэгдсэн төсөвт гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын оруулсан татварын орлого, хандив тусламж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос илүү их зардал, хохирол ирээдүйд гарч болзошгүй байдлыг судлан, үүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Төмрийн орд ашиглалт газрыг их хэмжээгээр онгичиж сүйтгэсэн байдлыг судлахын зэрэгцээ газар тариалангийн талбайн хөрс, ургацын бохирдолт, үүнээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх.
- Ашигт малтмалын нөөц шавхагдснаы дараах хор уршгийг арилгах, байгалийн нөхөн сэргээлтэд зарцуулах зардлын хэмжээг нарийн судлаж, өмнөх алдаа, дутагдлыг дахин давтахгүй байхад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Аливаа байгаль нийгэмд сөрөг үр дагавартай хоцрогдсон арга технологи хэрэглэх, хэрэглээгээр тодорхойлогдох техник-эдийн засгийн үндэслэл, төслөөсөө хэд дахин илүү их хүч чадлаар нөөцийг цөлмөн олборлохын эсрэг тодорхой арга хэмжээ авах, үр дагаврыг тооцох, зарим шаардлагагүй орд ашиглах, үйлдвэрүүдэд хөнгөлөлт олгохгүй байх, үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.


- Нутгийн уугуул иргэдийн малын бэлчээр гол горхи, булаг шанд, агаар, хөрс шороо, ой мод, малын бэлчээр, газар тариалангийн талбайн хөрс, хүн, мал, амьтан, таримал хүнс, малын өвс тэжээлийг бохирдуулан хор уршиг, гамшиг учруулж болзошгүй, хөрөнгө оруулалт-санхүүжилтийн хэмжээ бага, өндөр технологигүй дотоод гадаадын компанид төмрийн хүдрийн хайгуулыг, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байдаг хуулийн механизм бий болгох.
- Чанаргүй төмөр хийц, арматур үйлдвэрлэл, түүнийг барилгад хэрэглэн гэмт хэрэг үйлдэж байгаа дагнасан ба хамтарсан хөрөнгө оруулалттай компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж тэдгээрийн удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан нарт хуулийн хариуцлага хүлээлгэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.

ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРД, ИЛРЭЛИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ
масштаб 1:3 200 000



Зураг-12 Монгол орны төмрийн хүдрийн орд, илрэлийн байршлын зураг

INDEX MAP OF PLANNED AND SUPPOSED DEPOSITS UNTIL 2010, PLANNING CITIES



Зураг-13 Монгол Улсын хэтийн төлөв бүхий төслүүдийн байршил

Судалгааны ажлын нэгдсэн дүгнэлт

Дэлхийн төмрийн хүдрийн зах зээлд БНХАУ-ын нөлөө их байгаа бөгөөд төмрийн хүдрийг одоогоор хамгийн ихээр импортлож байгаа орон болж байна. Иймээс энэ зах зээлийн эрэлт хэрэгцээнээс хамааран төмрийн хүдэр, баяжмалын үнэ тодорхойлогдож байна. Иймээс манай улсын хувьд дараах асуудлуудад анхаарлаа хандуулах нь зүйтэй. Үүнд:

1. Нөөц нь бүрэн тогтоогдсон төмрийн хүдрийн ордуудыг ойрын жилүүдэд олборлон баяжуулж боловсруулсан бүтээгдэхүүн экспортлох, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах.
2. Төмрийн хүдрийн баяжуулах технологид дэлхийн түвшний стандартын, шаардлага тавих /Агуулгын хувийг харгалзан үзэх/
3. Үйлдвэрлэх цэвэр төмөр, баяжмал, олборлох хүдрийн зохистой харьцааг тодорхойлох, жил бүр экспортын бүтээгдэхүүн, квотын хэмжээг зохистой тогтоож байх
4. Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай зарим элементүүдийн эрэл хайгуулын ажил гүйцэтгэх, цаашид олборлох, үйлдвэрлэлд ашиглахад анхаарах
5. Байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх уурхайнуудыг ашиглахгүй байх, хяналт тавьж арга, хэмжээ авах.
6. Төмрийн хүдрийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
7. БНХАУ-ын импортын хэмжээ их байгааг харгалзан үзэж. Үнэ, олборлолт экспортын бүтээгдэхүүний зохистой хэмжээг тогтоох, цаашид бэлэн бүтээгдэхүүн экспортод гаргах талыг илүү баримтлах нь зүйтэй байна.

Ашигласан материал

1. Ц. Эрдэнэ, О. Зориг, Уул уурхайн салбарын татвар санхүүгийн тогтолцооны харьцуулсан судалгаа, 1999 он
2. Д. Жаргалсайхан, О. Зоригт, Д. Дашзэвэг, Д. Болор, Уул уурхайн салбарын татвар санхүүгийн тогтолцооны харьцуулсан судалгаа, 2000 он
3. Б. Батзул, Монгол Улсын уул уурхайн салбарын татварын таатай орчныг бүрдүүлэх замаар гадаадын хөрөнгө оруулалтыг татах зарим асуудал, 2004 он
4. Хууль тогтоомж, эмхэтгэлүүд,
 - i. Монгол улсын Татварын ерөнхий хууль
 - ii. Монгол улсын Ашигт малтмалын тухай хууль
 - iii. Монгол улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
 - iv. Монгол улсын Орлогын албан татварын тухай хууль
 - v. Монгол улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
 - vi. Монгол улсын Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татварын хууль,

5. Интернэтийн эх сурвалж:

1. <http://www.kitco.com/market>
2. <http://www.lme.com>
3. <http://www.metalprice.com>
4. <http://www.copper.org>
5. <http://www.neatideas.com>
6. <http://www.Bloomsbury Minerals Economics.com>
7. <http://www.basemetals.com>
8. <http://www.copper.org>
9. <http://www.bgr.bund.de>

10. <http://www.ft.com>
11. <http://news.tradingcharts.com>
12. <http://www.goldtrend.de>
13. <http://www.interfax.com>
14. <http://www1.metalbulletin.com>
15. <http://www.mines.edu>
16. <http://www.metalseconomics.com>
17. <http://gdr.nrcan.gc.ca>
18. <http://mmsd1.mms.nrcan.gc.ca>
19. <http://www.mining-journal.com>
20. <http://www.miningweekly.co.za>
21. <http://www.natural-resources.org/>
22. <http://www.theminingnews.org>
23. <http://minerals.usgs.gov>
24. <http://www.gold.org/>
25. <http://www.mining-journal.com>

-----ooOoo-----